

МОНГОЛ ДАХЬ АНХНЫ УЛС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ДАРГА НАР БҮГД КОММУНИСТУУД БАЙСАН УУ

С.Отгонжаргал.

Монгол Улсын Их Сургууль. Нийгмийн ухааны шинжлэх сургууль. Түүхийн тэнхим.

E-mail: otgoo@usa.com

Өгүүллийн товч утга: 1921 онд Монгол оронд үүссэн анхны улс төрийн байгууллагын удирдагчид нь коммунистууд байсангүй харин улс орноо хөрөнгөтний ардчилсан замаар хөгжүүлэхийг зорьж байсан өмчтөнгүүд байсан тухай МАН-ын дарга байсан япон хэмээгч А.Данзангаар төлөөлүүлэн өгүүлнэ.

Түлхүүр үг: коммунист, коммунизм, коммунист нам, хөрөнгөтний ардчилсан хувьсгал, хөрөнгөтөн.

Тэртээх 1920-иод оны үе нь дэлхийн олон улсын байдал хурцдаж хүчтэй нь хүчгүйгээ гэсэн онол эрээ цээргүй үйлчилж бага буурай улс орнуудыг их гүрнүүд эрх мэдэлдээ оруулах гэж өөр хоорондоо тэмцэлдэж байсан үе юм. Монгол улсын ерөнхий байдлыг товчхон дүгнэвэл хүчирхэг явсан Монгол нь түүхийн эрхээр гурав хуваагдан тасарч Буриат Монгол Оросын, Өвөр Монгол Хятадын салшгүй нэг хэсэг болсон байсан хийгээд голомтоо сахисан Халх Монголыг эзлэн түрэмгийлэх гэсэн бодлого хүчээ авч байв. Түүхэн эгзэгтэй энэ үед Монголд улс төрийн хоосон орон зай үүссэн байсан нь Монгол орны байдлыг ихээхэн хүндрүүлж орших уу эс орших уу гэдгийн зааг дээр ирээд байсан юм. Монгол улсыг харийнхан уу эсвэл монголчууд өөрсдөө эзэн нь болоод авч явах уу гэсэн хүнд үед монголчуудын амны хишгээр улс төрийн хоосон орон зайг дүүргэж анхны улс төрийн байгууллага үүсэж, удаж төдөлгүй МАН жинхэнэ ёсоор байгуулагдсан юм.

Дэлхий дахин түүгээр ч зогсохгүй монголд элэгтэй монгол судлаач нэрт эрдэмтэд ХХ зуунд жижиг буурай Монголыг тэсэж үлдэх эсэхэд эргэлзэж, Монгол улс мөхөх талаар өөр өөрсдийн таамаглалыг дэвшүүлж байсан нь саяхан юм. ХХ зууны эхээр Монголд байгуулагдсан улс төрийн энэхүү байгууллага нь гадны нэртэй эрдэмтдийн эргэлзээг тайлж өгөх төөрөг зурагтай байжээ. Монгол улс тэсэж үлдэхээр барах уу дэлхийн олон улсаар хүлээн зөвшөөрөгдсөн тусгаар тогтносон улс гэгдэж ХХI зуунтай золгосон нь монголын ард түмний өмнө гүйцэтгэсэн монголын анхны улс төрийн байгууллагын болон түүнийг удирдаж явсан лидерүүдийн үнэлж барахгүй том гавьяа байсан юм. Улс төрийн энэхүү томоохон байгууллагыг удирдаж явсан лидерүүд хэн байв аа?

Энд МАН гэсэн анхны улс төрийн байгууллагыг удирдаж явсан лидерүүдийн асуудлыг бүхэлд нь гаргаж тавих зорилго тавиагүй хийгээд ингэх ч боломжгүй нь ойлгомжтой юм. Харин энэ намыг удирдаж 1921 онд Намын Төв Хорооны дэд дарга, 1923-1924 онд МАН-ын дарга байсан Ажвайн Данзан гэж хэн байв аа, МАН-ыг толгойлж явсан энэ түүхт хүн **коммунист байв уу** гэсэн асуудлыг хөндөж тавихыг зорьсон болно. МАН-ын дарга А. Данзангийн үйл ажиллагаагаар МАХН-ын төрмөл шинж чанар дам боловч тодрох болов уу.

Коммунист гэж ямар хүнийг хэлэх вэ гэдэг асуултанд хариулахад үе үеийн шалгуурыг тооцсон хариулт байх нь тодорхой ч ерөнхий хүлээн зөвшөөрөгдсөн ойлголт байдгийг тэмдэглэх нь зүй юм. Эрдэмтэн Я. Цэвэлийн "Монгол хэлний товч тайлбар толь"-д коммунист гэж "1. коммунист намын гишүүн хүн, 2. коммунизмын үзэл санаа нэвтэрсэн, түүнийг илэрхийлэгч" хүнийг хэлнэ гэжээ. Коммунизм гэдэг үгийг уг толь бичигт "Эв хамт ёс, пролетарийн хувьсгал, пролетарийн дарангуйлан захирах засгийн ялалтын үрээр капитализмын оронд бий болох нийгэмлэгийн байгууллага"² гэж тайлбарлажээ.

К.Маркс, Ф. Энгельс нарын 1848 онд хэвлүүлсэн “Эв хамт намын тунхаг”-т энэ талаар юу гэж бичсэнийг тодруулцгаая. “Коммунистууд хэрэг дээрээ улс бүхний ажилчны намын ... эрс шийдэмгий хэсэг нь бөгөөд, онолын талаар пролетарын бусад олныг бодвол, пролетарын хөдөлгөөний нөхцөл байдал, явц, нийт үр дүнг ухамсарлан ойлгох талаар давуу байна”³ Коммунизмын онц шинж гэвэл ... хөрөнгөтний өмчийг хэрэгсэхгүй болгоно”⁴ “Энэ утгаар коммунистууд онолоо ганц өгүүлбэрээр илэрхийлвэл: хувийн өмчийг устгах явдал юм”⁵ гэжээ. (Монгол орчуулганд амины өмч гэсэн байсныг номын орос эхтэй тулган үзэж частная собственность гэдэг үгийг хувийн өмч гэж залруулав. С.О) Үүнээс үзвэл **коммунист, коммунизм гэдэг үг нь ажилчин ангитай харьцуулбал хавьгүй өндөр ухамсартай хүн, хувийн өмчгүй нийгэм** гэсэн утгыг илэрхийлж байдаг юм байна. Коммунист гэхээр ямар нэгэн намд харьяалагдах ёстой гэдэг нь дээрх тайлбаруудаас тодорхой байгаа юм. Я. Цэвэлийн тольд коммунистуудын харьяалагдах намыг коммунист нам, К. Маркс Ф. Энгельс нарын номонд ажилчны коммунист нам гэж тодорхойлсон байна. Улс төрийн намуудын талаарх ном, толь бичигт малчин ардын коммунист нам гэсэн үг үсэг, утга санаа ойрхон нэр томъёо тэмдэглэгдэж үлдсэнгүй.⁶ Ингэж үзвэл **өмчтөн малчин монголчуудын** 1921 онд байгуулсан МАН нь коммунист нам байх онолын үндэслэл байхгүй байгаа нь тодорхой юм. Монгол оронд коммунист нам боловсрон бүрэлдэх нийгэм, эдийн засаг, оюун санааны нөхцөл ч байгаагүйг дурдахад илүүдэхгүй биз ээ. Энэ утгаараа ч 1921 онд Монголд гарсан хувьсгал нь социализмыг баримжаалах боломжгүй байсан юм. Эрдэмтэн Ш. Бат-Очир 1957 онд хэвлүүлсэн бүтээлдээ уг хувьсгалыг “1921 оны манай ардчилсан хувьсгалын үүсэн гарах эдийн засгийн шаардлага нь жижиг өмчтөн натуралиг аж ахуйгаас ангижирч, жижиг товарын аж ахуйг чөлөөтэй хөгжүүлэх гэсэн эрмэлзлэг байсан юм. Энэ хувьсгалыг хийхэд дотоодын гол оролцсон хүч нь жижиг хувийн өмчтөн байсан учраас хөрөнгөтний ардчилсан хувьсгал гэж нэрлэж болно”⁷ гэж дүгнэсэн байдаг.

Коммунист намын гишүүнийг коммунист гэнэ гэсэн шалгуурт МАН-ын дарга А. Данзан тэнцэхгүй нь ойлгомжтой. Харин түүний үзэл санаа, өмчийг үзэх үзэл, төсөөлж байсан нийгэм нь коммунизмыг баримжаалж байв уу гэдгийг түүний товч намтар, намын дарга байхдаа хэрэгжүүлж байсан үйл ажиллагаагаар нь тодруулахыг зорихдоо ТЕГ Архивт хадгалагдаж буй материал, МАН-ын III их хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлд тулгуурласан болно.

1927.1. 26 өдөр. Харбин хотын хувцас захиалгын газарт нэгэн монгол хүн 57\$ 15 центээр савхин костюм, 65 \$ эрэгтэй пальто захиалснаа ирж авчээ. Тооцоогоо бэлнээр хийгээд гарав.⁸

Монгол улсын 19 он /1929/ 5-р сарын 13-нд Дундад улсын иргэн Сан-ва-и-хувийн 314 тоот дэлгүүрийн хашаа байшингаа нэгэн монгол хүнд бэлэн мөнгө 1600 төгрөгөөр худалдав.⁹

- 1931 оны 5-р сарын 6. Хотын захиргааны санхүүгийн хэлтсээс 4300 төгрөгний үнэ бүхий хувийн барилгын сар бүр төлөх татварыг тогтоожээ. Ноогдол татвар 43 төгрөг. Төлөх хугацаа сар бүрийн 26. Хувийн өмчийн эзэн тогтоосон хугацаанд нь татвараа төлж гарын үсгээ зурсан байна. Хориод оны ханшаар 100 \$, 1600 төгрөгийг бус 1 төгрөгний ханшийг тодорхойлоход л ямар хэмжээний мөнгө байв аа гэдэг нь хэн бүхэнд ойлгомжтой юм. 1981 онд хэвлэгдсэн “МАХН-ын ахмад ажилтан гишүүдийн дуртгал” эмхтгэлд ахмад гишүүн С. Гомбожав “Анх Алтанбулаг хотноо монголын харилцан туслалцах хоршооны Алтанбулаг дахь салбар байгуулагдаж хувь хөрөнгөнд 5 төгрөг, үндсэн хөрөнгөнд 1 төгрөгийг хураалгаж, хоршооны гишүүний үнэмлэх дэвтэр авч жилийн эцэст ашиг хуваарилж цай зэрэг барааг үнэгүйгээр олгоход нь гишүүд бид, нам засагтаа маш их баярлаж байдагсан”¹⁰ гэж дурссанаас

үзэхүл мөнгөний ханш ямар байсан нь тодорхой байгаа юм. **Энэ их баян хүн хэн байв аа?** МАН-ыг гардан байгуулалцаж, МАН-ын дарга явсан Япон хэмээгч Ажвайн Данзан байсан гэвэл та үнэмших үү. А. Данзангийн хөрөнгийн талаар ганц нэг мэдээг дурьдахад ийм байна.

МАН-ын дарга Данзан Түшээт хан аймгийн Хандчинвангийн хошуу одоогийн Булган аймгийн Могод суманд 1875 оны намрын дунд сарын сүүлээр Баатад овогт Ажвайн ганц хүү болон төржээ. Тэрээр бага наснаас томоохон хийдэд шавилан сууж байгаад номын мөр хөөж бурханы номонд улам их нэвтрэх чин хүсэлдээ хөтлөгдөн Төвд орныг зорьсон байна. 21 настай залуу хүү Лхас, Гүмбүн, Лавиран зэрэг олон газраар явж байхдаа өвөр монголчуудын амьдрал байдалтай нилээд ойр танилцаж, шашнаа хамгаалах тэмцэлд нь идэвхитэй оролцсоноор тэднийг дотночлох болсон нь түүний хожмын үйл ажиллагаанаас тодорхой байдаг. Данзангийн ийнхүү алс холыг зорих хүсэл тэмүүлэл нь биелэхэд түүний эцэг эхийн бэл бинчин нөлөөлсөн байна. Данзан Төвдөд очоод олон арван хүүхдүүдийн нэгэн адил бурханы номыг цээжилж ноомой явсангүй харин ч бурханы шашны томоохон төлөөлөгчид болох Далай лам, Банчин Эрдэнэ нартай ойр дотно танилцаж тэдний дотны хүн болсноор ертөнцийг үзэх үзэлд нь эрс өөрчлөлт оржээ. Төвдөд байхдаа тэрээр яагаад гэнэт шар шувталж, харын замыг сонгож, заавал Японыг зорьсон болон хэн түүнд нөлөөлсөн зэрэг нь учир битүүлэг үлджээ. Японд очиж Токиогийн ойролцоо Иокогама хотод суурьшин, ангийн арьс үсний пүүсийн эзэн хэмээгдэн алдаршихдаа японы үйлдвэр худалдаа, цэрэг улс төрийн нөлөө бүхий хүмүүстэй танилцаж байр сууриа бэхжүүлсэн¹¹ байсан тэрээр япон хэлэнд төдийгүй хятад, төвд, англи хэлийг идэвхийлэн сурч байв. Данзан Японд байх хугацаандаа Монголын талаар Орос, Хятад, Японы зүгээс явуулж буй бодлогыг ойлгосноор Монгол улсынхаа тусгаар тогтнолын төлөө зүтгэх цаг нь болжээ хэмээн үзэж 1905 онд эх нутагтаа эргэн ирэв. Тэрээр Өвөр Монголыг Ар Монголоос салгахгүйн төлөө идэвхийлэн зүтгэж хожим нь Хөлөнбуйрт нам байгуулалцаж, Өвөрмонголын тусгаар тогтнолын хөдөлгөөнийг удирдалцаж байжээ. Данзангийн энэхүү үйл ажиллагаа нь Чин ван Ханддоржийн шууд удирдлагаар явагдаж байсан нь өдгөө тодорхой болжээ.

Удалгүй А.Данзан Богд хаант Монгол улсын засгийн газрын тагнуулын албанд хүчин зүтгэх болж Хүрээнд Хятад, Солонгос иргэдийн дүрээр тагнуул хийж байсан Японы тагнуулчдын ажиллагааг илрүүлж, түүгээр ч зогсохгүй Нийслэл хүрээнд сууж байсан Японы тагнуул гэгдэх Козима, Сато нартай ойр дотно болж тэдний итгэлийг хүлээж байсан байдаг. 1916 онд Гадаад яамны сайд Б. Цэрэндоржийн даалгавраар Японд тусгай ажлаар томилогдож байв.

1919 онд Монголын тусгаар тогтнол аюулд ороод байсан үед А. Данзан монголын сэхээрэлт хэсэгтэй нягт холбоотой ажиллах болжээ. 1920 оны зун хувьсгалын долоо ЗОУ-аас тусламж гуйхаар явахад хувьсгалчдын нууц нэр, хоорондоо харилцах нууц түлхүүр үг зохиоход тагнуулын боловсролтой А. Данзан голлох үүргийг гүйцэтгэжээ. Мөн тэднийг Орос улс явсан хойгуур МАН гэдэг хувьсгалт байгууллагын тусгай даалгаврыг хүлээж гаминг тандах, хувьсгалчдын аюулгүй байдлыг хангах хариуцлагатай ажлыг түүнд даалгаж байв. Энэ үүргээ амжилттай биелүүлж байсны нэгэн жишээ гэвэл ардын журамт цэрэг хүрээг чөлөөлсөний дараа Д. Сүхбаатар өөрийн биеэр А. Данзангийн гэрт очиж хонуут өнжүүдээр дотносон уулзаж байсан хийгээд удаж төдөлгүй 1921 оны 7-р сард жанжин Д. Сүхбаатарын батлан даалттайгаар МАН-д гишүүнээр элссэнээс тодорхой байгаа юм. 1921 оны 10-дугаар сард А. Данзанг НТХ-ны дэд даргаар сонгожээ. 1921 оны 11-р сарын 24-нд хуралдсан МАН-ын Төв Хорооны гишүүдийн IX хурлаас Алс дорнодын хөдөлмөрчдийн их хуралд оролцох намын

төлөөлөгчдийн даргаар тэрээр сонгогдож явахдаа В.И.Ленинтэй уулзсан байна. Хэдхэн минут хоцорч ирсэн В.И.Ленин бүх төлөөлөгчидтэй мэндлээд Монгол үндэсний иж бүрэн хувцас өмссөн А.Данзан руу ойртон ирж "Та аль улсаас ирсэн ямар үндэстэн бэ" хэмээн асуухад "Би Чингисийн Монголын удам байна" хэмээн хариулж байсныг энэ хуралд оролцож байсан Японы төлөөлөгч Ёсида дурсамжиндаа тэмдэглэн үлдээжээ. Ийнхүү МАН-ын дарга А. Данзан **В.И. Ленинтэй уулзсан анхны монгол хүн** байлаа. 1922 оны 12-р сарын 30-нд хуралдсан НТХ-ны Тэргүүлэгчдийн 56-р хурлаас Москва хотноо суралцахаар болсон Намын дарга Ц. Дамбадоржийг даргын албанаас чөлөөлж, А. Данзанг түр орлуулж 1923 оны 1-р сарын 2-ны өдрийн ТХ-ны бүгд хурлын гишүүдийн 24-р хурлаар А. Данзанг МАН-ын даргаар тохоон томилжээ.¹² Энэ үеэс тэрээр Сангийн яамны зөвлөх түшмэлийн албыг давхар хаших болов.

1921 оны хувьсгалын зорилтод илт бэрхшээл учрах болсон түүхэн ээдрээтэй үед А. Данзан намын даргын хүнд албыг хаших болсон юм. ЗОУ-аас капиталист биш хөгжлийн замыг МАН-ын жанжин шугам болгох гэсэн бодлогыг дэмжигч хэсэг, энэхүү бодлогыг эрс эсэргүүцэж байсан хэсгийн чухам аль талд нь МАН-ын дарга А. Данзан байсан бэ? Энэ асуултанд хариулахын тулд түүхэн сурвалжинд түшиглэвэл илүү бодитой хариулт гарах байхаа. Капитализмын замыг эсэргүүцэх үзэл МАХН-ын III их хурал дээр хурцаар тавигдахад МАН-ын анхны дарга Солийн Данзан эрс эсэргүүцэж "Манай монголд хувийн хөрөнгийг хязгаарлах хэрэгтэй юу? Тийм тогтоол гаргаж болох бөгөөд би зөвшөөрнө. Харин одоогоор манай Монголд өөрийн хөрөнгөтнүүд байхгүй. Иймийн тулд энэ бол өнөөдрийн хэлэлцэх зүйл биш..."¹³ "Элбэгдоржийг Монголын төлөө явсан эх оронч үзэлтэй хүн юм гэж би урьд нь хууртан явжээ. Элбэгдорж бол оросоос суулгасан төрийн хутгуур. ... Элбэгдорж өнөөдөр намайг тонилгоод, маргааш та нарыг тонилгох болно"¹⁴ гэж хэлж байжээ. Энэ хурал дээр Элбэгдорж МАН-ын дарга А. Данзанг шүүмжилж "Данзангийн /Солийн С.О/ ажил явууллага аль ч талаар үзсэн болохыг байлаа. Тийм учраас Данзаны /Солийн/ ажил явууллагыг хэлэлцэхийн тулд өөрийн нь оролцуулан хариуцлагатай хүмүүсийг хуралдуулахаар шийдвэрлээд хурлын зорилгыг Данзанд /Солийн/ хэлэхгүй гэж тогтсон билээ. ... Гэтэл Төв Хорооны дарга Япон Данзан /А. Данзан С.О/ өөрийнхөө санаж байснаар Данзаныд очиж бүгдийг хэлжээ".¹⁵ Мөн "Данзан /Солийн С.О/ бүх монгол овогтныг нэгтгэх тухай илтгэл тавихын тулд Нийслэл Хүрээний намын үүрүүдийн бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулах гэсэн өргөдлийг Төв Хороонд оруулав. Ийм чухал хэргийг Төв Хороонд урьдчилан хэлэлцэлгүй олны өмнө тавьж болохгүй гэж би учрыг гаргаж хичнээн эсэргүүцсэн боловч Нийслэл Хүрээний үүрүүдийн төлөөлөгчдийг үүр тутмаас 10 хүн бодож хуралдуулахыг Төв Хороо зөвшөөрчээ. / А. Данзан С.О /¹⁶ гэснээс үзэхэд МАН-ын дарга А. Данзан социализмыг баримжаалах замыг эсэргүүцэж байсан нь тодорхой байгаа юм.

Түүхийн шинжлэх ухааны доктор, эрдэмтэн Ч. Дашдаваа МАН-ын III их хурлын эцсийн шийдвэрийг "Улаан түүх" номондоо "Их хурал МАН-ын түших тулах нь гагцхүү дунд ба хоосон ядуу этгээд болох тухай Э. Ринчино болон бусад хүмүүсийн саналыг хүлээн авч, түүнийг их хурлаас гаргасан тогтоолд тусгасан байна. Харин Э. Ринчиногийн дэвшүүлсэн бусад саналууд, ялангуяа "Монгол Ардын Намын эцсийн зорилт нь эв хамтын ёс мөн бөгөөд нам капитал хөрөнгөтний хөгжлийн шатыг алгасан энэ зорилгод хүрэхээр явж байна гэсэн үзэл баримтлалыг МАН-ын III их хурал хүлээж аваагүй байна"¹⁷ МАН-ыг коммунист нам болгон хувиргах гэсэн Э. Ринчиногийн оролдлого ийнхүү бүтээгүй билээ. Их хурал С. Данзангийн удирдлагаар боловсруулж баталсан НТХ-ны тайлан илтгэлийн тухай тогтоолд "монгол улс бүх дэлхийн олон улстай адил

харгис капиталтан хөрөнгөтний дарлагдал зовлонг үл амсан, олон улсын одоогийн байдалд нийлүүлэн, жинхэнэ ардын ёсыг баримтлан зоривол зохино” гэсэн шийдвэрийг капиталист бус хөгжлийн замаар Монгол орныг хөгжүүлэх түүхэн шийдвэр гаргасан хэмээн олон жилийн турш сурталчилж ... ирсэн байна”¹⁸ гэж түүхэн үнэнийг анх дэвшүүлэн тавьжээ. Чингэж үзвэл МАН-ыг коммунист нам болголгүй авч үлдсэн үндэсний сэхээрэлт лидерүүдийн нэг нь МАН-ын дарга Япон хэмээгч А. Данзан байсан нь гарцаагүй юм. Энэ ч учраас ч А. Данзангийн тушаал бууж МАН-ын дэд дарга болж, удалгүй ЗОУ-д суух Элчин сайдаар “зайлуулагджээ”. Зайлуулагдсан гэдэг үгийг илтгэгч Э. Ринчиногийн хэлж байсан үгнээс авснаа тэмдэглэе. Уг Их хурал дээр Э. Ринчино “ Намайг Москвад суух элчин зөвлөхөөр явуулж эндээс / Монголоос С.О/ зайлуулах гэсэн оролдлого Төв Хороогоор орсон юм. ... Янз нь Данзаны этгээдүүд их хурлыг тараахаас өмнө намайг эндээс танилгох гэсэн бололтой”¹⁹ гэж хэлж байжээ. Ринчиногийн үгээр МАН-ын дарга А. Данзан ийнхүү зайлуулагдсан юм.

А. Данзан 1924 онд ЗОУ-д суух Элчин сайдаар томилогдсон боловч хүсэлт гаргаснаар 1925 онд энэ ажлаасаа чөлөөлөгджээ. 1926-1928 онд Хятадын Бээжин, Шанхай, Тяньжин, Нанжин, Харбин хотуудад Харилцан туслалцах хоршооны төлөөлөгчөөр сууж байхдаа тэрээр Орос, Япон, Хятад, Төвд, Англи хэлнийхээ мэдлэгийг ашиглан гадаадын олон пүүс компаниудтай экспорт, импортын улсын худалдааг амжилттай хөгжүүлэхийн зэрэгцээ хувийн худалдаагаа давхар хөгжүүлж байв. Тэрээр хувьсгалын өмнө Токиогийн ойролцоо Иокогама хотод байгуулсан байсан нэр хүнд бүхий ангийн арьс үсний пүүсээ улам хөгжүүлэхийн дээр Японд хувийн банкны салбараа нээсэн тухай дам мэдээ байдаг. Түүнийг өсөн бойжиж буй хөрөнгөтөн этгээд хэмээн 1928 онд Хятадаас дуудаж худалдаа наймааных нь ажлаас хөндийрүүлэн Судар бичгийн хүрээлэнд ажиллуулжээ. Энд ажиллахдаа тэрээр Англи-Монгол хэлний толь, Монгол-Төвд-Япон хэлний харьцуулсан толь зохиожээ. А.Данзан Монгол орноо хөрөнгөтний замаар хөгжүүлэх МАН-ын үндсэн бодлогыг хэрэгжүүлэхэд тууштай зүтгэж Англи, Америк, Япон, Герман мэргэжилтнийг өргөн ашиглах бодлого явуулж, мөн Герман, Япон, Дани улсад монголын залуучуудыг сургах ажлыг идэвхийлэн хөөцөлдөж байжээ. А.Данзанг 1932 онд Японы тагнуул хэмээн хилс хэрэгт баривчилжээ.

Баривчилсан мэдүүлэгт :1932 оны 2-р сарын 24-ний өдөр. Хууль ёсоор учир ухуулан байцааваас Баатад овогт Ажвайн Данзан 1875 онд төрсөн, нас 57, урьд лам явсан, Түшээт хан аймгийн Хандчинвангийн хошууны хүн. Улаанбаатар хотын 17-р хороонд амьдарч байсан, гэрийн дотор гагцаар амьдардаг, хөрөнгө хувь 37, сонгуулийн эрхтэй, ял шийтгүүлж яваагүй.²⁰ гэжээ. Тэрээр дэндүү хэрсүү хүн байсан учир хилсээр тулгасан хэргийг хүлээгээгүйн улмаас түүнийг сэтгэл мэдрэлийн эмнэлэгт хүчээр хэвтүүлсэн байна. Түүний нас барсан тухай эмчийн актанд :1932 оны 6-р сарын 1-ний оройн 9 цаг. Ардын эрүүлийг хамгаалах явдлын яамны хий судлал ба галзуу өвчтөний больниц. Дотоодыг хамгаалах газарт. 6-р сарын 1-ний оройн 9 цагт ялтан Данзан нь өвчний учир бие барсныг мэдэгдье. Эмч - Профессор Ильян.²¹ гэжээ.

МАН-ын дарга Япон хэмээгч А.Данзан 1932 онд “сэтгэл зүйн” өвчний улмаас гэсэн оноштойгоор учир битүүлгээр нас баржээ.

МАН-ын дарга Япон хэмээгч А. Данзан коммунист байсан уу.

Abstract

The article tells that the leaders of the first political organization in Mongolia (1921) were not communists but they were the petty proprietors who wanted that Mongolia developed along the bourgeois democratic road. The author tells it on the example of the Head of the Mongolian People's Party Ajvain Danzan.

Ашигласан материал

1. Я. Цэвэл. "Монгол хэлний товч тайлбар толь". УБ. 1966. х. 315
2. мөн тэнд.х.315
3. Эв хамт намын тунхаг. УБ. 1947. х. 63
4. мөн тэнд. х.64
5. мөн тэнд
6. Л.М. Энтин Политические системы развивающихся стран. М.1978. Дипломатический словарь. М. 1984. Том I. М.1985. Т- II. М. 1986. Т-III
7. Ш.Бат-Очир. "БНМАУ-ын шилжилтийн харьцааны үеийн зарим асуудал". УБ. 1957. х. 9.
8. ТЕГТА. Ф-1. Т-14. ХН-Ц-1299. х. 63. 69.
9. мөн тэнд. х.29
10. "МАХН-ын ахмад ажилтан гишүүдийн дуртгал" эмхтгэл. 1981.
11. Үнэн сонин. 1995. №25
12. УТА. Ф-1. Т-1. ХН-193.х.164
13. МАХН-ын III их хурал х.59
14. мөн тэнд.х.169
15. мөн тэнд.х.168
16. мөн тэндх.168
17. Ч.Дашдаваа. "улаан түүх". УБ.2003. х.95
18. мөн тэнд х.96
19. мөн тэнд х.189
20. ТЕГТА.Ф-1.Т-14.ХН-Ц-1299.х.6
21. ТЕГТА.Ф-1.Т-14.ХН-Ц-1299.х.9